



МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 25-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН ГИШҮҮДИЙН ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь хэсэг, 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын цалин, урамшууллын хэмжээ, 2022 оны үйл ажиллагааны нийт төсвийг 310,200,000 /Гурван зуун арван сая хоёр зуун мянган/ төгрөгөөр баталсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд нь хууль болон бусад холбогдох дүрэм, журамд заасан эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, төсвийг үр ашигтай захиран зарцуулахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ОЮУН



МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 25-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ДҮГНЭЛТҮҮД, 2022 ОНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 2022 оны 04 сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Хавсралт №01-ээр, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг Хавсралт №02-оор, Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөг Хавсралт №03-аар тус тус баталсугай.
2. Тайлант оны үйл ажиллагааны ололтоо бататган, эрхэм зорилго, зорилтоо биелүүлэхэд тодорхой бодлого чиглэл боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон компанийн удирдлагуудад даалгасугай.
3. Компанийн санхүү, бизнесийн үйл ажиллагаанд хийсэн Аудитын хорооны зөвлөмж, дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг компанийн Санхүү, эдийн засгийн хэлтэст үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ОЮУН